



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2023 оны 12 сарын 15 өдөр

Дугаар А/158

Улаанбаатар хот

「Аудитын тайланг баталгаажуулах тухай」

Төрийн аудитын тухай хуулийн 9 дүгээр зүйл, 29 дүгээр зүйлийн 29.1.9 дэх заалт, 29.2, 29.3, 29.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Хөгжлийн банкны үйл ажиллагааны үр нөлөө, үр ашиг” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр, албан шаардлагын жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.


2.Аудитын тайланг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо болон Хөгжлийн банканд тус тус хүргүүлэхийг Гүйцэтгэл-нийцлийн аудитын газар (Д.Энхболд)-т үүрэг болгосугай.

3.Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2024 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Хөгжлийн банкны гүйцэтгэх захирал (Ж.Батаа)-д зөвлөсүгэй.

4.Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг Гүйцэтгэл-нийцлийн аудитын газар (Д.Энхболд)-т даалгасугай.

5.Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон Үндэсний аудитын газрын архивд хүлээлгэн өгөхийг Гүйцэтгэл-нийцлийн аудитын газар (Д.Энхболд)-т үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ОРЛОГЧИЙН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.НАРАНЧИМЭГ



Аудитаар тогтоосон албан шаардлагын жагсаалт

№	Төлбөр, зөрчил хариуцах		Төлбөрийн акт, зөрчлийн албан шаардлагын товч утга	Төлбөрийн актын дүн (төгрөгөөр)	Албан шаардлагын дүн (төгрөгөөр)
	Байгууллага	Албан тушаалтан			
1	Монгол Улсын Хөгжлийн банк	Захирал Ж.Батаа	УИХ-ын 81 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх үед Монгол Улсын Хөгжлийн банкны зохистой харьцааны холбогдох шалгуур үзүүлэлтийг сайжруулах төслөөр "Сайншанд аж үйлдвэрийн цогцолбор" ТӨХХК-ийн МУХБ дахь 3600000577USD дансанд 550.4 мянган ам.доллар (1,881,817,600.00 төгрөг), 3600000578MNT дансанд 77.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан бөгөөд Засгийн газрын 2018 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн 9 дүгээр тогтоолоор Сайншанд аж үйлдвэрийн цогцолборыг татан буулгах шийдвэр гарснаар дээрх дансны үлдэгдлийг эргэлтэд оруулж, үр нөлөөг гаргаагүй зөрчил илэрснийг таслан зогсоох, дансны үлдэгдэлийг улсын төсөвт төвлөрүүлэх.	-	1,881,894,700.00
2	Монгол Улсын Хөгжлийн банк	Захирал Ж.Батаа	УАГ-аас тус банкны 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар өгсөн 2 зөвлөмж ...үл хөдлөх хөрөнгийн үнэ цэний бууралт, ...дотооддоо боловсруулж, батлуулсан НББ-ийн бодлогын баримт бичиггүй..., УАГ-аас 2022 онд өгсөн 626/A0150053, 627/A0150053, 628/A0150053, 638/A0150053, 639/A0150053, 640/A0150053, 641/A0150053, 642/A0150053, 634/A0150053, 633/A0150053, 635/A0150053, 637/A0150053, 636/A0150053 дугаартай 13 албан шаардлага нь бүрэн хэрэгжээгүй байна.	-	-
	Монгол Улсын Хөгжлийн банк	Захирал Ж.Батаа	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.9 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8 дэх хэсэгт заасныг Монгол Улсын хөгжлийн банкны 2 охин компани хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төсвийн хуульд заасан цагалбарт хугацаанд Төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй байна.	-	-
	Нийт		1.Тус банкны охин компани болох "Ди Би Эм ассет менежмент ХХК" -ийн 2020, 2022 оны санхүүгийн тайлангаа Төрийн аудитын байгууллагад хүргүүлээгүй. 2. Ди Би Эм лизинг ХХК-ийн 2020, 2021, 2022 оны санхүүгийн тайлангаа Төрийн аудитын байгууллагад тус тус ирүүлээгүй.	-	1,881,894,700.00

АГУУЛГА

Товчилсон үг.....	4
Хүснэгтийн жагсаалт.....	4
Дүрслэлийн жагсаалт	4
Ерөнхий мэдээлэл	6
БҮЛЭГ 1. МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНК 2020-2021 ОНЫ ХООРОНД 81.6-306.7 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН АЛДАГДАЛТАЙ АЖИЛЛАЖ, 2023 ОНЫ 12 САРЫН 14-НИЙ БАЙДЛААР ЧАНАРГҮЙ ЗЭЭЛ 1,270.1 ТЭРБУМ ТӨГРӨГ БУЮУ 56.3 ХУВЬД ХҮРЧ ӨССӨН БАЙНА	7
<i>Хөгжлийн банк нь 2020-2021 онд 86.1 тэрбумаас 306.7 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллаж байсан бол 2022 онд 88.6 тэрбум төгрөгийн ашигтай гарсан байна.....</i>	<i>7</i>
<i>Тус банк 2023 оны эхний хагас жилийн байдлаар 67.4 тэрбум төгрөгийн алдагдалтай байгаа нь зорилтот үр дүнг бүрэн хангах боломжгүй байна.</i>	<i>9</i>
<i>Зээлийн үлдэгдэл 2023 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн байдлаар 40 зээлдэгчийн 2,254.6 тэрбум төгрөг болж, үүнээс чанаргүй зээл 1,270.1 тэрбум буюу 56.3 хувьд хүрч өссөн байна.</i>	<i>9</i>
<i>2023 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн байдлаар дараах 12 зээлдэгчийн 313.8 тэрбум төгрөгийн зээл хаагдсан байна.....</i>	<i>10</i>
<i>Засгийн газрын 2022 оны 220 дугаар тогтоолд дурдагдсан 3 төрийн өмчит хуулийн этгээдэд олгосон зээлүүдэд төлөлт хийгдээгүй байна</i>	<i>11</i>
<i>2021-2022 онд хэмнэлтийн зарчмыг баримталж зардлыг хэмнэх, тэвчих, бууруулах зарчмыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.....</i>	<i>11</i>
<i>Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 1-16 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна</i>	<i>12</i>
БҮЛЭГ 2. МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНКАНД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН БАЙГУУЛЛАГУУДААС ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН 58.4 ХУВЬ НЬ ХЭРЭГЖЭЭГҮЙ БАЙНА... 13	13
<i>Монгол Улсын Их Хурлын 2022 оны хяналт шалгалтын зөвлөмжийн 72.7 хувь нь биелээгүй байна .</i>	<i>13</i>
<i>УИХ-ын 2023 оны хянан шалгах түр хорооноос өгсөн зөвлөмжийн 60 хувь нь биелээгүй байна.....</i>	<i>15</i>
<i>ҮАГ-аас 2021-2022 оны өгсөн зөвлөмжийн 17 хувь, албан шаардлагын 62.5 хувь нь биелээгүй байна</i>	<i>16</i>
<i>Монголбанкны зөвлөмжийн 38.5 хувь нь хэрэгжээгүй байна</i>	<i>17</i>
<i>Олон улсын аудитын компаниас өгсөн зөвлөмжийн 47 хувь нь хэрэгжээгүй байна</i>	<i>18</i>
<i>Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг тус банкны охин компани хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангаа хуульд заасны дагуу Төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй байна.</i>	<i>18</i>
Дүгнэлт:	20
Зөвлөмж:	21

Товчилсон үг

БХБС	Барилга, Хот байгуулалтын сайд
БХС	Батлан Хамгаалахын сайд
ГҮТББ	Гишүүддээ үйлчилдэг төрийн бус байгууллага
ДАШЦББ	Дарханы арьс ширний цогцолборын бүтээн байгуулалт
ЗТХС	Зам, тээврийн хөгжлийн сайд
МУХБ	Монгол улсын хөгжлийн банк
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
ТББ	Төрийн бус байгууллага
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨҮГ	Төрийн өмчийн үйлдвэрийн газар
ТӨХК	Төрийн өмчийн хувьцаат компани
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТХТХ	Төрийн хэмнэлтийн тухай хууль
УИХ	Улсын Их Хурал
УЦС	Усан цахилгаан станц
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ЭХС	Эрчим хүчний сайд

Хүснэгтийн жагсаалт

Дугаар	Гарчиг	Хуудас
Хүснэгт 1	Санхүүгийн бизнес төлөвлөгөөний хэрэгжилт	7
Хүснэгт 2	Зээлийн чанарын ангилал, зээлдэгчийн тоо, хүүгийн орлого олдоггүй зээл, зээлдэгчийн тооны нэгтгэл, /тэрбум төгрөг, тоо/	9
Хүснэгт 3	Засгийн газрын 220-р тогтоолд тусгагдсан зээлүүд	10
Хүснэгт 4	Нийт бараа, үйлчилгээ худалдан авалтын төлөвлөгөө гүйцэтгэлийн 2020-2022, 2023 оны эхний хагас жил. сая төгрөг, хувь	11
Хүснэгт 5	Шилэн дансны нэгдсэн цахим системд мэдээлэл байршуулсан судалгааны нэгтгэл	11

Дүрслэлийн жагсаалт

Дугаар	Гарчиг	Хуудас
Дүрслэл 1	Хүний нөөцийн хөдөлгөөн	6
Дүрслэл 2	МУХБ-ны ашиг/алдагдал 2020-2023	7
Дүрслэл 3	Зөвлөмжийн хэрэгжилтийн нэгтгэл	12
Дүрслэл 4	Зөвлөмжийг тайлагнасан байдал	13

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2022 оны 9 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/04 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2023 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэв.

Аудитын зорилго, зорилтууд

Монгол Улсын Хөгжлийн банкны /цаашид МУХБ гэх/ үйл ажиллагаа, санхүүжүүлсэн төсөл хөтөлбөрийн үр нөлөө, үр ашгийг тооцож, дүгнэлт зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн.

Аудитын зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэв. Үүнд:

1. Нийгэм эдийн засагт үр нөлөө үзүүлэх төсөл, хөтөлбөрт олгосон зээлийн эргэн төлөлтөд тавих хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлсэн эсэх;
2. Хөндлөнгийн хяналтаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр нөлөөг тооцсон уу?

Аудитын хамарсан хүрээ

Аудитад МУХБ-ны 2020-2022 он, 2023 оны эхний хагас жилийн үйл ажиллагаа, санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн зээлийн эргэн төлөлт, түүний үр дүн, өмнөх жилүүдэд Хөгжлийн банкны үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар өгсөн зөвлөмж, төслийн орлогоос эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр шууд олгосон зээл, Засгийн газрын холбогдох тогтоолуудын дагуу арилжааны банкаар дамжуулан олгосон зээлийг түүврийн аргаар хамруулж, хэрэгжилт хангалтгүй төслүүдийн шалтгаан нөхцөлийг тодорхойлох чиглэлээр ажиллав.

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 300, 3000-3100 үндэслэн боловсруулсан Гүйцэтгэлийн аудитын журамд заасан арга зүйг ашиглан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдлөг болгон аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, байгууллагын үйл ажиллагааны болон зээл олголт, санхүүгийн тайлан, бусад шаардлагатай баримт материал, аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитыг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, Аудитын менежер Н.Анхбаяр, ахлах аудитор М.Наранжаргал, Б.Эрдэнэбат, аудитор А.Мөнхбадрал, Х.Шинэбаяр, Д.Доржнамжим, С.Оюун-Эрдэнэ нар гүйцэтгэв.

Аудитын явцад учирсан хүндрэл, бэрхшээлүүд:

Хувийн хэвшлийн зээлийн эргэн төлөлтийн асуудлууд хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн нь холбогдох материалтай танилцах боломж хязгаарлагдмал байсан тул аудитын хамрах хүрээнд оруулаагүй болно.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын хөгжлийн банкны тухай хуулийг анх 2011 онд баталж, 2017 онд хуульд шинэчлэн найруулга хийсэн бөгөөд хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т “Хөгжлийн банк нь үндэсний эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах тэргүүлэх салбаруудад хэрэгжих төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх, импортыг орлох, экспортын орлогыг нэмэгдүүлэх үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилготой, энэ хуулийн 8.1¹-д заасан үйл ажиллагааг эрхлэх чиг үүрэг бүхий ашгийн төлөө хуулийн этгээд байна”... гэж заасан байна.

Мөн Монгол банкны Ерөнхийлөгчийн 2017 оны А-286 дугаар тушаалаар тус банканд төрийн өмчийн төрөлжсөн банкны гэрчилгээ олгож, гадаад валют худалдах, худалдан авах, хадгалуулах энгийн зөвшөөрлийг зөвхөн ханшийн эрсдэлээс хамгаалах зорилгоор Төв банкттай гадаад валютын своп, спот хэлцэл хийх нөхцөлөөр, үнэт цаас гаргах, худалдах, худалдан авах нэмэлт зөвшөөрлийг Төв банкны үнэт цаасны хоёрдогч захын арилжаанд оролцох, Засгийн газрын богино хугацаат үнэт цаас худалдах, худалдан авах нөхцөлтэйгөөр олгожээ.

Засгийн газрын 2010 оны 195 дугаар тогтоолоор “Монгол Улсын Хөгжлийн банк” байгуулж, дүрмийг баталсан бөгөөд 2011 оны 151 дүгээр, 2017 оны 123 дугаар, 2020 оны 129 дүгээр, 2021 оны 252 дугаар тогтоолоор хуулийн этгээдийн дүрмийг 4 удаа шинэчлэн баталсан байна.

“Монгол Улсын Хөгжлийн банк” ХХК-ийн төрийн эзэмшлийн хувьцаа эзэмших эрхийг² Засгийн газрын 2020 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн 122 дугаар тогтоолоор Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлж байх шийдвэрийг гаргасан байна.

Хөгжлийн банкны төлөөлөн удирдах зөвлөл нь ердийн 5, хараат бус 4 гишүүн, тэдгээрийн дундаас сонгогдсон даргын бүрэлдэхүүнтэйгээр бүрэн эрхээ хэрэгжүүлж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 8 дугаар сарын 03-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор гүйцэтгэх захирал Н.Мөнхсүхийг чөлөөлж, мөн өдрийн 20 дугаар тогтоолоор Н.Мандуулыг томилсон. 2023 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 28 дугаар тогтоолоор гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Н.Мандуулыг чөлөөлж, мөн өдрийн 29 дүгээр тогтоолоор Ж.Батааг томилжээ.

Тус банкны ТУЗ-ийн 2022 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 28 дугаар тогтоолоор Хөгжлийн банкны зохион байгуулалтын бүтцийг төлөөлөн удирдах ажлын алба, дотоод аудитын газар, гүйцэтгэх захирал, тэргүүн дэд захирал, банкны ажилтнууд бүхий нийт 129 хүнтэй байхаар орон тооны дээд хязгаарыг тогтоосон байна. Хөгжлийн банкны гүйцэтгэх захирлын 2023 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн А-39 дүгээр тушаалаар банкны орон тоог тэргүүн дэд захирал болон 7 газар, нэгж бүхий нийт 118 ажилтантай байхаар шинэчлэн баталсан байна.

“Монгол Улсын Хөгжлийн банк” ХХК-ийн эзэмшилд “Ди Би Эм Лизинг” ХХК, “Ди Би Эм Ассет менежмент ҮЦК” ХХК гэсэн 2 охин компани харьяалагддаг бөгөөд хувьцааг 100 хувь эзэмшдэг байна.

Монгол Улсын Хөгжлийн банкны хувь нийлүүлсэн хөрөнгө 2021 он 12 сарын 31-ний өдрийн байдлаар 1.2 их наяд төгрөг байсан, 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар 3.9 их наяд төгрөг болж, Монгол Улсын Засгийн газар 100 хувь эзэмшиж байна.

¹Хуулийн 8.1.Хөгжлийн банк дараах үйл ажиллагаа эрхэлнэ: 8.1.1.төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх; 8.1.2.төлбөр тооцоо хийх; 8.1.3.баталгаа, батлан даалт гаргах; 8.1.4.үнэт цаас гаргах, санхүүгийн хэрэгсэл худалдах, худалдан авах, хадгалуулах; 8.1.5.зээл авах; 8.1.6.гадаад валют худалдах, худалдан авах, хадгалуулах; 8.1.7.компанийн хувьцаа эзэмших, хөрөнгө оруулалтын санд хөрөнгө оруулалт хийх; 8.1.8.төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор зөвлөх үйлчилгээ үзүүлэх; 8.1.9.экспорт, импортын санхүүжилт хийх; 8.1.10.төлбөрийн чадварыг сайжруулах, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх зорилгоор богино, дунд хугацаатай санхүүгийн эх үүсвэр татан төвлөрүүлэх.

²Төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг ЗГХЭГ 2016 оноос эхлэн хэрэгжүүлж байсан.

БҮЛЭГ 1. МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНК 2020-2021 ОНЫ ХООРОНД 81.6-306.7 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН АЛДАГДАЛТАЙ АЖИЛЛАЖ, 2023 ОНЫ 12 САРЫН 14-НИЙ БАЙДЛААР ЧАНАРГҮЙ ЗЭЭЛ 1,270.1 ТЭРБУМ ТӨГРӨГ БҮЮУ 56.3 ХУВЬД ХҮРЧ ӨССӨН БАЙНА

Тус банкны хүний нөөцийн хөдөлгөөн ихтэй байгаа нь үйл ажиллагаагаа тогтвортой явуулахад хүндрэл учрахаар байна.

1.1. Тус банканд 2020-2023 оны хугацаанд ТУЗ-ийн тогтоолоор 5 удаа орон тооны дээд хязгаарыг баталж, 3 удаагийн бүтэц, зохион байгуулалт хийсэн байна.

Бүтэц зохион байгуулсан хийсэн хугацаа	Орон тооны дээд хязгаар
2019.07.05-2020.04.24	149
2020.04.24-2021.08.27	110
2021.08.27-2021.11.09	127
2021.11.09-2022.05.13	131
2022.05.13-2023.12	129

1.2 Хүний нөөцийн хөдөлгөөнийг сүүлийн 3 жил буюу 2020-2023 оны байдлаар авч үзэхэд 125 ажилтан ажилд шинээр орж, нийт 173 ажилтан ажлаас чөлөөлөгдсөнөөс 83 (48%) ажилтан өөрийн хүсэлтээр, 90 (52%) ажилтан ажил олгогчийн санаачилгаар хөдөлмөрийн гэрээгээ цуцалсан бөгөөд 2022 онд 44 ажилтан ажилд орж, 57 ажилтан ажлаас чөлөөлөгдсөн нь хамгийн өндөр үзүүлэлттэй буюу тогтвортой үйл ажиллагаа явуулах нөхцөл алдагдсан байна. Тухайлбал:

- Ажил олгогчийн санаачилгаар хөдөлмөрийн гэрээг цуцалсан нийт 90 ажилтнаас хөдөлмөрийн гэрээний хугацаа дууссан шалтгаанаар 13,3 хувь, бүтэц, зохион байгуулалт, орон тооны өөрчлөлтөөр 57,8 хувь, өндөр насны тэтгэвэр тогтоолгосон 2,2 хувь, бусад /эрүүл мэнд, захиргааны санаачилгаар г.м/ шалтгаанаар 26,7 хувь нь ажлаас чөлөөлөгджээ.
- Ажлаас чөлөөлөгдсөн 173 ажилтны 24,6 хувь нь гүйцэтгэх удирдлага, 6,9 хувь нь ахлах ажилтан, 57,2 хувь нь гүйцэтгэх албан тушаалтан, 11,0 хувь нь үйлчилгээний ажилтнууд байна.

Дүрслэл 1: Хүний нөөцийн хөдөлгөөн



Хөгжлийн банк нь 2020-2021 онд 86.1 тэрбумаас 306.7 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллаж байсан бол 2022 онд 88.6 тэрбум төгрөгийн ашигтай гарсан байна.

1.3 Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1³ дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1.2⁴ дахь заалтыг үндэслэн ТУЗ-ийн 2019 оны 75, 2021 оны 08, 2021 оны 40, 2022 оны 67 дугаар тогтоолуудаар Монгол Улсын Хөгжлийн банк /цаашид тус банкны гэх/-ны 2020-2023 он тус бүрийн бизнес төлөвлөгөөг баталсан байна. Тухайлбал:

³ 18.1.Хөгжлийн банкны эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал, түүний чөлөөт цагт төлөөлөн удирдах зөвлөл байна
⁴ 20.1.2.Хөгжлийн банкны тухайн жилийн бизнес төлөвлөгөөг батлах

- Тус банкны гүйцэтгэх удирдлагын багаас 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр боловсруулж, ТУЗ-ын дэргэдэх аудитын хорооны 2021 оны 1 дүгээр сарын 18-ний өдрийн шийдвэрээр ТУЗ-д танилцуулсан ч ТУЗ-өөс 2021 оны 7 дугаар сарын 08-ний өдөр бизнес төлөвлөгөөг баталсан нь 2021 оны төсөвлөлт, төлөвлөгөөг хугацаа хоцроон баталсан нь 2021 оны 1-6 сарын хооронд бизнес төлөвлөгөөгүй үйл ажиллагаа явуулжээ.

1.4 Тус банкны 2020-2022 он, 2023 оны эхний хагас жилийн бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг санхүүгийн байдлын тайлан, орлого үр дүнгийн тайлангаар авч үзвэл 2020-2021 онд төлөвлөснөөс 18.1-20.2 хувиар биелээгүй, 2022 онд 102.1 хувиар биелж, нийт өр төлбөр төлөвлөснөөс 2020-2022 онд 20.9-12.1 хувиар, 2023 оны эхний хагас жилд 3.6 хувиар тус тус биелээгүй байна. Үүнд:

Хүснэгт 1: Санхүүгийн бизнес төлөвлөгөөний хэрэгжилт тэрбум
төгрөг

Үзүүлэлт	2020			2021			2022			2023.06.30		
	Төл.	Гүйц.	Гүйц. (%)	Төл.	Гүйц.	Гүйц. (%)	Төл.	Гүйц.	Гүйц. (%)	Төл.	Гүйц.	Гүйц. (%)
Нийт хөрөнгө /актив/	5,119.5	4,191.4	81.9%	4,676.0	3,729.2	79.8%	3,943.8	4,025.4	102.1%	4,110.3	3,745.5	91.1%
Үүнээс зээлийн багц	3,694.0	3,378.9	91.5%	3,536.8	3,205.8	90.6%	3,964.0	2,641.8	66.6%	1,912.4	2,446.8	127.9%
Нийт өр төлбөр /пассив/	4,034.6	3,192.8	79.1%	3,589.5	3,040.7	84.7%	3,689.4	3,244.2	87.9%	3,324.4	3,033.4	91.2%
Нийт өөрийн хөрөнгө	1,084.9	998.6	92.0%	1,086.6	688.5	63.4%	254.4	781.2	307.1%	785.9	712.1	90.6%

Эх сурвалж: МУХБ-ны бизнес төлөвлөгөөний хэрэгжилт.

Тухайлбал:

- Бизнес төлөвлөгөөний биелэлт 2020-2021 онд 81.9-79.8 хувийн, 2022 онд 102.1 хувийн гүйцэтгэлтэй гарч, 2023 оны хагас жилийн байдлаар Монгол Улсын Хөгжлийн банкны активын үлдэгдэл 3.7 их наяд төгрөг байна. Үүнээс нийт активын хамгийн их 1,560.8 тэрбум төгрөг буюу 41.7 хувийг цэвэр зээлийн авлага, 1,025.7 тэрбум төгрөг буюу 27.4 хувийг мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө эзэлж байна. 2020 онтой харьцуулахад нийт хөрөнгө 446 тэрбум төгрөгөөр буурсан шалтгаан нь 2021 онд их хэмжээний зээлийн эрсдэлийн сан байгуулсантай холбоотой байна.
- Нийт өр төлбөрийн төлөвлөгөөний биелэлт 2020-2022 онд 79.1-87.9 хувь, 2023 оны хагас жилийн байдлаар 91,2 хувьтай байна. Банкны 2023 оны хагас жилийн байдлаар өр төлбөрийн 2,896.1 тэрбум төгрөг буюу 95,4 хувийг банкнаас гаргасан үнэт цаас ба өрийн бичиг, гадаадын банкнаас авсан зээл эзэлж байна.
- Нийт өөрийн хөрөнгө 2020-2022 онуудад 18.5-23.8 хувийг эзэлж, 2023 оны хагас жилийн байдлаар 18.2 хувь буюу 712.1 тэрбум төгрөг эзэлж байна.
- Мөн банк нь 2020 онд 86.1 тэрбум, 2021 онд 306.7 тэрбум төгрөгийн татварын дараах алдагдалтай байсан бол 2022 онд 88.6 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна.

Дүрслэл 2: МУХБ-ны ашиг/алдагдал 2020-2023 тэрбум төгрөг



Эх сурвалж: МУХБ-ны бизнес төлөвлөгөөний хэрэгжилт.

Тухайлбал: Дэлхий нийтийг хамарсан Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын нөлөөгөөр МУХБ-ны 2020-2021 оны бизнесийн төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээ нь бүрэн хэрэгжээгүй, үр дүнд хүрээгүй байна. Үүнд:

2020 он:

- Тус банк нь 2020 онд зээлийн эргэн төлөлт 422.5 тэрбум, зээл олголт 603.4 тэрбум төгрөг байхаар төлөвлөсөн ч стратегийн ач холбогдол бүхий газар тариалангийн салбарт 76.3 тэрбум, ноос ноолуурын салбарт 63.9 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлүүдийг олгосон нь 23.2 хувийг эзэлж, 86.1 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

2021 он:

- МУХБ-ны бизнес төлөвлөгөөний хэрэгжилт 74 хувь, эх үүсвэр, гадаад харилцааны хэрэгжилт 64 хувь, активын чанарыг сайжруулах ажлын хэрэгжилт 53 хувь, зээл санхүүжилтийн үйл ажиллагааны хэрэгжилт 41 хувьтай гэж тайлагнасан,
- Мөн Монголбанкнаас банкны үйл ажиллагаанд хийсэн шалгалтын дүгнэлтээр зээлийн эрсдэлийн санг нэмж байгуулах акт ирүүлсэн ба хөндлөнгийн аудитын байгууллагаас эхний хагас жилийн эцсээр 349.4 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн санг нэмж байгуулжээ.
- Мөн онд зээлийн багцын үндсэн төлбөрөөс 486.6 тэрбум төгрөгийн зээл эргэн төлүүлэхээс 402.1 тэрбум төгрөг төлүүлж гүйцэтгэл 83 хувь, багцын хүүгийн эргэн төлөлт 84.7 тэрбум төгрөг буюу 72 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнаж, 306.7 хувийн алдагдалтай ажилласан байна,

Тус банкны 2022 оны бизнесийн төлөвлөгөөний хэрэгжилт төлөвлөсөн үр дүнд хүрч, нийт 641.0 тэрбум төгрөгийн 16 зээлийг хааж, 88.6 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна.

- Үйл ажиллагааны хэрэгжилт 68 хувь, эх үүсвэр, гадаад харилцааны хэрэгжилт 73 хувь, активын чанарыг сайжруулах ажлын хэрэгжилт 43 хувь, зээл санхүүжилтийн үйл ажиллагааны хэрэгжилт 86 хувьтай байна.
- Зээлийн багцын үндсэн төлбөрөөс 298.3 тэрбум төгрөгийн зээл эргэн төлүүлэхээр төлөвлөсөн бол тайлант онд 818.6 тэрбум төгрөг төлүүлж гүйцэтгэл 274 хувь, багцын хүүгийн эргэн төлөлт 267.7 тэрбум төгрөг буюу 195 хувийн гүйцэтгэлтэй байна.

Тус банк 2023 оны эхний хагас жилийн байдлаар 67.4 тэрбум төгрөгийн алдагдалтай байгаа нь зорилтот үр дүнг бүрэн хангах боломжгүй байна.

1.5 Тус банкны 2023 оны биенесийн төлөвлөгөөний хэрэгжилт 2023 оны эхний хагас жилийн байдлаар 6 зээлдэгчийн 132.3 тэрбум төгрөг эргэн төлөгдөж, олон улсын зах зээлд гаргасан Евро бондын эргэн төлөлтөд 500.0 сая ам.долларыг барагдуулсан ч, 67.4 тэрбум төгрөгийн алдагдалтай байгаа нь зорилтот үр дүнг бүрэн хангахааргүй байна. Тухайлбал:

- Бизнес төлөвлөгөөнд 2023 онд 1,149.5 тэрбум төгрөгийн зээл барагдуулалт хийхээр төлөвлөсөн бол эхний хагас жилийн байдлаар 262.8 тэрбум төгрөгийн эргэн төлөлт хийгдэж, 23 хувийн гүйцэтгэлтэй, 328.7 тэрбум төгрөгийн зээл олгохоор төлөвлөснөөс 5,8 тэрбум төгрөгийн зээл олгож 2 хувийн гүйцэтгэлтэй байна.
- Евро бондын эргэн төлөлтийн 500.0 сая ам.доллороос 150.8 сая ам.долларыг хэсэгчлэн худалдан авч, нийт эргэн төлөлтийн 30 хувийг бүрдүүлсэн ба 2023 оны 11 дүгээр сарын байдлаар олон улсын зах зээлд гаргасан 500 сая ам.долларын эргэн төлөлтийг бүрэн төлж барагдуулсан байна.
- Зээлийн багц 2023 оны эхний хагас жилийн байдлаар нийт 2,446.8 тэрбум төгрөгөөс 886.0 тэрбум төгрөг буюу 36.2 хувьд нь эрсдэлийн сан байгуулсан байна.

Зээлийн үлдэгдэл 2023 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн байдлаар 40 зээлдэгчийн 2,254.6 тэрбум төгрөг болж, үүнээс чанаргүй зээл 1,270.1 тэрбум буюу 56.3 хувьд хүрч өссөн байна.

1.6 Тус банкны “Эрсдэлийн удирдлагын” газраас зээлийн үнэ цэнэ бууралтыг тооцоолж, зээлийн нийт үлдэгдэлд зээлийн эрсдэлийн сан байгуулах, хувь хэмжээг тохируулах гүйлгээг хийж, харгалзах ангиллыг 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар тогтоосон байна.

Хүснэгт 2: Зээлийн чанарын ангилал, зээлдэгчийн тоо, хүүгийн орлого олдоггүй зээл, зээлдэгчийн тооны нэгтгэл, /тэрбум төгрөг, тоо/

	2020	2021	2022	2023.12.14
Хэвийн	1,780.2	838.3	621.6	801.9

“Хөгжлийн банкны үйл ажиллагааны үр нөлөө, үр ашиг” аудитын тайлан

Анхаарал хандуулах	715.3	859.4	601.9	182.5
Чанаргүй	883.5	1,508.1	1,418.3	1,270.1
үүнээс хүүгийн орлого олдоггүй	93.4	272.8	1,124.0	1,054.4
үүнээс ЗГ-ын тогтоолын дагуу санхүүжүүлсэн зээлийн үлдэгдэл	252.1	256.2	350.7	309.7
Зээлдэгчийн тоо	72	66	52	40
үүнээс хүүгийн орлого олдоггүй зээлдэгчийн тоо	7	8	23	22

Эх сурвалж: МУХБ

1.7 Тус банкнаас эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах тэргүүлэх салбаруудад хэрэгжих томоохон төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх, урт хугацааны хөгжлийн хөрөнгө оруулалт хийх чиг үүргийн хүрээнд олгосон зээлийн үлдэгдэл 2020 оны эцэст нийт 72 зээлдэгчийн зээлийн нийт үлдэгдэл 3,379.0 тэрбум төгрөг, үүнээс чанаргүй зээл 883.5 тэрбум буюу 26.2 хувьтай байсан бол 2023 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн байдлаар 40 зээлдэгчийн зээлийн нийт үлдэгдэл 2,254.6 тэрбум төгрөг болж, үүнээс чанаргүй зээл 1,270.1 тэрбум буюу 56.3 хувьд хүрч өссөн байна. Үүнд:

- “Эрэл” ХХК, “Пи Си Вай” ХХК, “Пирамид-Орд” ХХК, “Чингис Хаан” Банк нь муу зээлийн ангилалтай;
- “Хөтөл” ХХК, “Газ-Импорт” ХХК, “Инжир” ХХК, “МБҮ Трейд” ХХК, “Монгол Драй Милк” ХХК, “Монгол Микрон Кашмер” ХХК, “Мондулаан Трейд” ХХК, “НВЦ” ХХК, “Промон Трейд” ХХК, “Сэлэнгийн Герефорд” ХХК, “Төрийн Орон Сууцны Корпорац”, “Энсада-Истерн” ХХК-ууд нь эргэлзээтэй зээлийн ангилалд багтаж байна.

Тухайлбал:

- Засгийн газрын 2022 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 124 дүгээр “Хөтлийн цемент шохой” ТӨХК-ийн хувьчлалын талаар авах арга хэмжээний тухай” тогтоолоор 2015 онд Засгийн газраас гаргасан хувьчлах зүйлсийн жагсаалтад багтсан тус компанийн хувьчлалыг хүчингүй болгох шийдвэр гарч, цемент шохой үйлдвэрийг төр өөрийн өмчлөлд шилжүүлэн авсан. “Хөтлийн цемент шохой” ТӨХК-ийн зээлийн үлдэгдэл 2023 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн байдлаар 377.5 тэрбум төгрөг бөгөөд тус ТӨХК-ийн үйлдвэрийн барилга байгууламжийг Улсын комисс хүлээн аваагүй байна.
- Засгийн газрын 2018 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн “Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 02 дугаар тогтоолын дагуу МУХБ-аас “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХК-д зээл олгосон ба уг зээлийн гэрээний дагуу 2023 оноос зээлийг эргэн төлөх байсан боловч зээлийн гэрээний нөхцөлд өөрчлөлт орж 2026 оны 4 дүгээр сарын 26-ны өдрөөс зээлийн хүүгийн төлбөрийг, 2027 оны 4 дүгээр сарын 26-ны өдрөөс зээлийн үндсэн төлбөрийг төлж эхлэхээр болсон байна.

1.8 Мөн 2020-2023 онд хүүгийн орлого олдоггүй⁵ зээлдэгч 7-22, зээлийн хэмжээ 93.4 -1,140.0 тэрбум болж өсөж, олгосон зээлийн хэмжээ 2020-2022 онд 252.1-350.7 тэрбум төгрөг, Засгийн газрын 2023 оны 34, 132 дугаар тогтоолын дагуу 2023 оны эхний хагас жилд 351.1 тэрбум төгрөг болсон байна.

2023 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн байдлаар дараах 12 зээлдэгчийн 313.8 тэрбум төгрөгийн зээл хаагдсан байна

1.9 Тус банкнаас 32 зээлдэгчийн 1,456.7 тэрбум төгрөгийн зээлийг 2018 оноос 2023 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн хооронд хуулийн байгууллагад шилжүүлснээс Иргэний хэргийн шүүхэд 21 зээлдэгчийн 1,051.7 тэрбум, Эрүүгийн хэргээр шалгуулахаар 11 зээлдэгчийн 405.0 тэрбум төгрөгийн зээлийг тус тус шилжүүлсэн байна.

Харин 2023 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн байдлаар дараах 12 зээлдэгчийн 313.8 тэрбум төгрөгийн зээл хаагдсан байна. Үүнд:

1. Модун ХХК 1,460.5 сая төгрөг
2. Шанх майнинг ХХК 57.5 сая төгрөг
3. Мак цемент ХХК 119,554.2 сая төгрөг
4. Мон лаа ХХК 7,565.1 сая төгрөг
5. Монполимет ХХК 87,096.6 сая төгрөг
6. Дархан минж ХХК 810.5 сая төгрөг
7. Эйч энд эйч ремикон ХХК 931.1 сая төгрөг
8. Ган хүдэр орд ХХК 2,440.5 сая төгрөг

⁵ Шүүхэд шилжүүлсэн

9. Хатант интернэшнл ХХК 4,760.5 сая төгрөг
10. Говь ХК 84,219.5 сая төгрөг
11. Комплант ХХК 4,355.9 сая төгрөг
12. Строй-инвест ХХК 587.6 сая төгрөг

Засгийн газрын 2022 оны 220 дугаар тогтоолын 1.3, 1.5, 1.8-д дурдагдсан 3 төрийн өмчит хуулийн этгээдэд олгосон зээлүүдэд төлөлт хийгдээгүй байна

1.10 Засгийн газар 2022 оны 5 дугаар сарын 31-ний өдөр 220 дугаар тогтоолоор БХБС, БХС, ЭХС, ЗТХС, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, “Эрдэнэс Монгол ХХК-ийн ТУЗ-д зээлийн өр төлбөрийг барагдуулах чиглэлийг өгч, зээлийн эргэн төлөлт 2023 оны 12 дугаар сарын 14-ний байдлаар 426.6 тэрбум төгрөгийн төлөлтөөс 180.5 тэрбум төгрөгийг үнэт цаасаар, 246.1 тэрбум төгрөгийг мөнгөн хөрөнгөөр барагдуулсан байна. Үүнд:

Хүснэгт 3: Засгийн газрын 220 дугаар тогтоолд тусгагдсан зээлүүд.

	<i>төгрөг</i>				
ЗГ-ын 220 тогтоолд тусгагдсан зээлүүд	2022.12.31 үлдэгдэл	2023.01.01-2023.12.14-ны төлөлт	2023.12.14 Хүү алданги	2023.12.14 Үндсэн үлдэгдэл	2022.06.01-2023.12.14 эргэн төлөлт
ТОСК /БУ-1/	-	-	-	-	79,456,466,896.1
ТОСК /БУ-2/	-	-	-	-	106,189,744,149.9
ТОСК БОНД	180,962,376,712.3	7,650,232,876.7	7,440,061,643.8	180,500,000,000.0	15,300,465,753.4
ТОСК “Хөдөлгөөнт цогцолбор”	25,649,932,438.1	-	6,395,153,807.4	19,254,778,630.7	-
Нийслэлийн орон сууцны корпораци	63,620,278,308.9	9,573,922,093.8	4,017,803,022.0	54,121,602,294.0	17,542,229,287.0
Эрдэнэс Монгол ХХК	42,871,585,767.7	45,856,268,561.8	-	-	164,503,313,969.4
Эрчим Хүчний Яам (Таван толгой ДЦС)	58,356,011,073.7	-	10,273,560,480.7	50,699,729,296.9	-
Эгийн голын усан цахилгаан станц ТӨХХК	56,310,944,820.1	-	23,716,894,240.2	36,268,764,706.3	-
МИАТ ТӨХК	-	-	-	-	15,016,154,227.2
ХААДС	54,846,440,971.0	26,055,426,365.0	14,160,000.0	31,922,234,623.1	28,597,397,508.6
Нийт төлөлт ба Зээлийн үлдэгдэл	482,617,570,091.8	89,135,849,897.3	51,857,633,194.1	372,767,109,551.0	426,605,771,791.6
Үнэт цаасаар хийсэн төлөлт					180,500,000,000.0
Бэлэн мөнгөөр хийсэн төлөлт		89,135,849,897.3			246,105,771,791.6

Эх сурвалж: МУХБ

1.11 Засгийн газар 2022 оны 220 дугаар тогтоолд дурдагдсан төрийн өмчит хуулийн этгээдэд олгосон зээлүүдээс ТОСК “Хөдөлгөөнт цогцолбор”, Эрчим хүчний яам (Таван толгой дулааны цахилгаан станц), “Эгийн голын УЦС” ХХК-ийн зээлүүдэд тогтоол гарснаас хойш эргэн төлөлт хийгдээгүй байна.

2021-2022 онд хэмнэлтийн зарчмыг баримталж зардлыг хэмнэх, тэвчих, бууруулах зарчмыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна

1.12 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”, 2022 онд батлагдсан Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу тус банк нь 2021-2022 онд хэмнэлтийн зарчмыг баримталж зардлыг хэмнэх, тэвчих, бууруулах зарчмыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна. Тухайлбал:

- Тус банкнаас 2021 онд Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хүрээнд хэмнэлтийн зарчмыг баримталж зардлыг хэмнэх, тэвчих, бууруулах зарчмаар төсвийг төлөвлөн батлуулсан ч тухайн жилийн санхүүгийн аудитлагдсан тайланд зочин төлөөлөгчийн зардалд 9.2 сая, баяр ёслол арга хэмжээний зардалд 22.6 сая, спорт арга хэмжээний зардалд 12.3 сая төгрөг, хэвлэл мэдээллийн зардалд 46.4 сая төгрөг нийт 90.5 сая төгрөгийн үргүй зардал гаргасан;
- 2022 онд байгууллагын үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай шууд холбоотой бус сургалтад 12.1 сая, үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 197.7 сая төгрөгийн үлдэх өртөгтэй 1 жип, 4 суудлын машин, 1 автобус, нийт 6 автомашиныг шилжүүлээгүй, холбогдох албан тушаалтан 4 удаагийн гадаад албан томилолтоор айлчлахдаа гадаадын агаарын тээврийн компанийг сонгон үйлчлүүлснээс

“Хөгжлийн банкны үйл ажиллагааны үр нөлөө, үр ашиг” аудитын тайлан

31.4 сая төгрөгийг арвилан хэмнэлтгүй зарцуулж, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 9.2 “...үндэсний агаарын тээвэрлэгчийг сонгож үйлчлүүлнэ” гэж заасныг, Банк, санхүүгийн академи ТББ-д 8.0 сая, Монголбанкны холбоо ГҮТББ-д 12.0 сая, Монголын тогтвортой санхүүгийн холбоо ТББ-д 8.0 сая, нийт 28.0 сая төгрөгийг гишүүнчлэлийн төлбөрт зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12.1.4-т “хуулиар зөвшөөрөөгүй бусад” гэж заасныг тус тус зөрчиж, уг хуулийг бүрэн мөрдөж ажиллаагүй байна.

1.13 Үйл ажиллагааны зардлын нэгдсэн төсвийг 2023 онд 18.2 тэрбум төгрөгөөр баталж, 2023 оны эхний хагас жилд 5.4 тэрбум төгрөг буюу 29.9 хувийг зарцуулснаас үндсэн хөрөнгө худалдан авалт 49.1 хувийг эзэлж байна. Банкны батлагдсан орон тоо 129 бөгөөд 2023 оны 3 дугаар улирлын байдлаар 98 ажилтантайгаар үйл ажиллагаа явуулснаар цалингийн зардал 33 хувиар хэмнэгдсэн байна.

1.14 Тус банкны нийт бараа, үйлчилгээ худалдан авалтын төлөвлөгөөнд 2020 онд 2,085.8 сая төгрөг, 2021 онд 1,897.6 сая төгрөг, 2022 онд 1,616.6 сая төгрөг, 2023 онд 2,011.9 сая төгрөгийг баталсан нь 2022 оны дүнтэй харьцуулахад 2021-2022 онд 9.0-22.5 хувиар, 2023 онд 3.5 хувиар буурсан бөгөөд тус зардлын 2020 оны гүйцэтгэл 1,009.9 сая төгрөг, 2021 онд 594.0 сая төгрөг, 2022 онд 594.0 сая төгрөг, 2023 оны эхний хагас жилд 217.5 сая төгрөг гарч, 2020 оны гүйцэтгэлтэй харьцуулахад 2021 он, 2022 он тус бүрд 41.2 хувиар буурсан байна.

Хүснэгт 4: Нийт бараа, үйлчилгээ худалдан авалтын төлөвлөгөө, гүйцэтгэлийн 2020-2022, 2023 оны эхний хагас жил. сая төгрөг, хувь

Үзүүлэлт	2020			2021			2022			2023.06.30		
	Төл	Гүйц	Биелэлт	Төл	Гүйц	Биелэлт	Төл	Гүйц	Биелэлт	Төл	Гүйц	Биелэлт
НИЙТ худалдан авалт	2,085.80	1,009.90	48.4%	1,897.60	594	31.3%	1,616.60	594	36.7%	2,011.90	217.5	10.8%
Үндсэн үйл ажиллагаатай холбоотой	1,405.80	563.6	40.1%	1,358.70	333.8	24.6%	1,521.20	333.8	21.9%	1,869.20	144.4	7.7%
Хөрөнгө худалдан авалт	680	446.3	65.6%	538.9	260.2	48.3%	95.4	260.2	272.7%	142.7	73.1	51.2%

Эх сурвалж: МУХБ

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 1-16 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна

1.15 Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг 2020-2022 он, 2023 оны эхний хагас жилийн байдлаар авч үзэхэд 2020 онд 16, 2021 онд 7, 2022 онд 4, 2023 оны эхний хагас жилд 1 мэдээллийг тус тус хугацаа хоцроож мэдээлсэн байна. Үүнд:

Хүснэгт 5: Шилэн дансны нэгдсэн цахим системд мэдээлэл байршуулсан судалгааны нэгтгэл

Он	Мэдээллийн төрөл	Мэдээллийн тоо	Хоцорсон мэдээллийн тоо	Хоцорсон мэдээллийн хувь
2020	19	197	16	8.1%
2021	21	194	7	3.6%
2022	21	185	4	2.2%
2023.06.30	27	83	1	1.2%

Эх сурвалж: МУХБ

Тухайлбал:

- 2020-2021 онд хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт болон бусад хэсгийн мэдээллийг хугацаа хоцроож “Шилэн дансны нэгдсэн” системд оруулж, 2022 онд “Концессын мэдээлэл”, “Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах өр, авлага, үүсгэсэн аливаа шийдвэр” цэсэд оруулах мэдээлэл байгаагүй ч энэ талаар хоцорч мэдээлсэн, мөн жилийн эцсийн байдлаар “Худалдан авах ажиллагааны тайлан” цэсэд мэдээллийг хоцроож оруулсан байна.
- Шилэн дансны цахим хуудас өөрчлөгдөж мэдээллийг 2023 оны 1 дүгээр сараас эхлэн тус хуудаст оруулж, 2023 оны эхний хагас жилийн байдлаар нийт 27 төрлийн 83 мэдээллийг хуулийн хугацаанд оруулж тайлагнасан, “Аудитын тайлан дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан” мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

БҮЛЭГ 2. МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНКАНД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН БАЙГУУЛЛАГУУДААС ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН 58.4 ХУВЬ НЬ ХЭРЭГЖЭЭГҮЙ БАЙНА

2.1 Тус банкны үйл ажиллагаанд 2020-2022 оны байдлаар УИХ, УАГ, Монгол банк, Сангийн яам зэрэг төрийн байгууллага болон хөндлөнгийн аудитын “Кэй Пи Эм Жи Аудит” ХХК зэрэг эрх бүхий байгууллагаас хяналт шалгалт, аудит хийж нийт 154 зөвлөмжийг өгснөөс 64 буюу 41.6 хувь нь биелж, 90 буюу 58.4 хувь нь биелээгүй нь ТУЗ болон дотоод аудитын хорооноос зөвлөмж хэрэгжүүлэх, шийдэл чиглэлийг тухай бүр гаргаагүйтэй холбоотой байна.


Дүрслэл 3: Зөвлөмжийн хэрэгжилтийн нэгтгэл



Эх сурвалж: Аудитын баг

2.2 Эрх бүхий байгууллагаас хийгдсэн хяналт шалгалт, аудитын зөвлөмжийн хэрэгжилт, биелэлтийг холбогдох байгууллагад дараах хугацаанд хүргүүлж, харин 2020 онд Сангийн яам болон Монголбанкны хамтарсан шалгалтын ажлын хэсэг нь хяналт шалгалтын тайланг тус банканд ирүүлээгүйгээс зөвлөмжийн хэрэгжилтийг тайлагнаагүй байна. Үүнд:

Дүрслэл 4: Зөвлөмжийг тайлагнасан байдал



Эх сурвалж: МУХБ

Монгол Улсын Их Хурлын 2022 оны хяналт шалгалтын зөвлөмжийн 72.7 хувь нь биелээгүй байна

2.3 Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, шалгалт хийсэн талаарх Монгол Улсын Засгийн газар, Монгол банк болон аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжтэй танилцаж дүнг УИХ-д танилцуулах үүрэг бүхий “Ажлын хэсэг” УИХ-ын даргын 2022 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 20 дугаар захирамжаар байгуулагдаж, тус

банкны санхүүгийн болон зээлийн үлдэгдэл, холбогдох мэдээллийг 2021 оны тайлант хугацаагаар тасалбар болгож хяналт шалгалтыг гүйцэтгэсэн байна.

2.4 УИХ-ын 2022 оны 20 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн хяналтын тайланд 22 анхаарах асуудал, 33 санал зөвлөмж, Засгийн газрын түвшинд шийдвэрлэх шаардлагатай 53 зээлдэгчийн 2,425.9 тэрбум төгрөгийн зээлийн үүргийг хангуулах зөвлөмж гаргасан ч санал, зөвлөмжийг хэрэгжүүлэх хугацааг тодорхой заагаагүй байна. Үүнд:

- Төрөөс хэрэгжүүлэх бодлого, арга хэмжээнд анхаарах 3 асуудалд 3 санал зөвлөмж,
- Засаглал, бүтэц зохион байгуулалт хүний нөөцийн анхаарах 6 асуудалд 7 санал, зөвлөмж,
- Зээлийн үйл ажиллагаанд анхаарах 9 анхаарах асуудалд 13 санал, зөвлөмж,
- Барьцаа хөрөнгийн анхаарах 2 асуудалд 2 санал, зөвлөмж,
- Хөгжлийн банкны санхүүгийн нөхцөл байдал, санхүүгийн удирдлагын анхаарах 2 асуудалд 2 санал зөвлөмж,
- “Төрийн өмчит компаниуд”-ын зээлийн үүргийн гүйцэтгэлийг хангуулах 13 зээлдэгчийн 1,054.8 тэрбум, “Хувийн хэвшлийн компаниуд”-ын зээлийн үүргийн гүйцэтгэлийг хангуулах 30 зээлдэгчийн 1,092.1 тэрбум, Авлигатай тэмцэх газар шалгагдаж байгаа 10 зээлийн 278.5 тэрбум төгрөгийн зээлийг Засгийн газрын түвшинд шийдвэрлэх шаардлагатай гэж тус тус заасан байна.

2.5 Аудитын явцад УИХ-ын 2022 оны 20 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн хяналтаас өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар авч үзэхэд 33 санал зөвлөмжөөс “Засгийн газар цаашид дэд бүтцийн салбар дахь бодлогын тогтвортой байдлыг хангах” санал, зөвлөмжийг Засгийн газарт өгсөн нь тус банкнаас хэрэгжилтийг тайлагнаагүй байна. Тайлагнасан 32 санал, зөвлөмжөөс 9 буюу 27.3 хувь хэрэгжсэн, 14 буюу 43.8 хувь нь хэрэгжиж байгаа, 4 буюу 12.5 хувь хэрэгжих шатанд, 5 буюу 15.6 хувь хэрэгжээгүй, санал зөвлөмжийн биелэлт 27.3 хувьтай байна.

2.6 Зээлийн эргэн төлөлт нь зөрчилтэй зээлдэгчдийн эрсдэл өндөр тул хувийн хөрөнгө оруулалтын сангууд хамтран ажиллах сонирхолгүй, зээл авсан компаниудын орлогын болон зарлагын гүйлгээг хянах зорилгоор “Corporate gateway” нэвтрүүлэх саналыг арилжааны банкнуудад хүргүүлсэн ч хариу ирүүлээгүй, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8.1.4⁶ дэх заалт хэрэгжээгүй, “Актив удирдлагын компанийн тухай” хуулийн төсөл дэмжигдээгүй зэрэг шалтгаанаас дараах 5 санал, зөвлөмж хэрэгжээгүй байна. Үүнд:

Хэрэгжээгүй санал, зөвлөмж:

1. “Хувийн хөрөнгө оруулалтын сангуудтай санхүүжилт олгох, зээлийг худалдаж авах, зарах чиглэлээр хамтран ажиллах” ... хувийн хөрөнгө оруулалтын сангууд зөрчилтэй зээлдэгчдийн эрсдэл өндөр гэж үздэг тул хамтран ажиллах сонирхолгүй
2. “Хөгжлийн банканд зээл авсан компаниудын орлогын болон зарлагын гүйлгээг нь хянах боломж олгох”...зээл авсан компаниудын орлогын болон зарлагын гүйлгээг хянах зорилгоор “Corporate gateway” нэвтрүүлэх, арилжааны банкнуудад хамтран ажиллах тухай санал хүргүүлсэн ч хариу ирүүлээгүй,
3. “МУХБ-аас төрийн өмчит компанид зээл олгоход байгуулж буй зээлийн барьцааны гэрээг холбогдох хуульд нийцтэй болгож өөрчлөх”... төрийн өмчийг барьцаалахтай холбоотой Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8.1.4 дахь заалт хэрэгжээгүй,
4. “Төрийн өмчит үйлдвэрийн газар, компанид зээл олгох, эд хөрөнгийг барьцаалах шаардлагыг тусгасан хуулийн заалтын хэрэгжилтийг хангуулж ажиллах” ... төрийн өмчийг барьцаалахтай холбоотой Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8.1.4 дахь заалт хэрэгжээгүй,
5. “Активын удирдлагын компани байгуулж, зээлийг эрсдэл, хугацаа, хэмжээ, зориулалтаар нь ангилан үе шаттай худалдаж авах, зарах боломжийг олгох, хуримтлуулсан мөнгөн хөрөнгөөр төслүүдэд тодорхой дэмжлэг үзүүлэх, улмаар зээлийн эргэн төлөлтийг хангуулах” ... “Актив удирдлагын компанийн тухай” хуулийн төсөл боловсруулах шатанд дэмжигдээгүй байна

2.7 Тус банк нь “Зээлийн бодлого” болон “Төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх шийдвэр гаргах журам”-ыг ТУЗ-д танилцуулж, ЗГ-ын 2022 оны 220 дугаар тогтоолын хүрээнд эргэн төлөлт хийгдээгүй,

⁶ 8 дугаар зүйл Төрийн өмчийн талаарх УИХ-ын бүрэн эрхийн 8.1.4-т⁶ төрийн өмчийг барьцаалах, орон нутгийн өмчид шилжүүлэх тухай шийдвэр гаргах”

чанаргүй ангилалд хамаарах зарим зээлийг хууль, шүүхийн байгууллагатай хамтран, шүүхийн бус журмаар зээлийг төлүүлж байгаа ч дараах төслүүд хэрэгжих шатанд байна.

Хэрэгжих шатанд байгаа санал, зөвлөмж:

1. “МУХБ-ны тухай хуулийн 10.1 дэх хэсэгт заасан Хөгжлийн банкнаас санхүүжүүлэх төсөл хөтөлбөрт тавигдах шаардлагыг хангасан эсэхийг үнэлэх, дүгнэлт өгөх тодорхой шалгуур, аргачлал, зааврыг шинэчилж мөрдөх” ... “Зээлийн бодлого”, “Төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх шийдвэр гаргах журам”-ын шинэчилсэн найруулгын төсөлд Хөгжлийн банкнаас санхүүжүүлэх төсөл хөтөлбөрт тавигдах шаардлагыг нэмэгдүүлж, түүнд үнэлэлт дүгнэлт өгөх шалгуур, аргачлал, зааврыг тусгасан,
2. “Найдваргүй болсон зээлдэгчийн хувьд зээлийн гэрээний нөхцөлийг өөрчлөх замаар төслийн мөнгөн урсгалд үндэслэн зээлийн эргэн төлөлтийн хуваарьт өөрчлөлт оруулах, сунгах болон бүтцийн өөрчлөлт хийх, зээлийн хэлбэрийг өөрчлөх, барьцаа нэмэгдүүлэх шаардлага тавих зэрэг арга хэлбэрийг судалж, зохион байгуулах арга хэмжээ авсны эцэст шүүхээр шийдвэрлүүлэх хувилбарт шилжиж байх”... шүүхийн бус журмаар зээлийг төлүүлэх ажиллагаагаар 4 зээлдэгчдийн зээлүүд хаагдсан ч төрийн өмч болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн зээл “Эгийн голын усан цахилгаан станц” төсөл, “Таван толгойн дулааны цахилгаан станц” төсөл, ТОСК “хөдөлгөөнт цогцолбор” зэрэг зээлүүдэд төлөгдөөгүй,
3. “Санхүүгийн хүндрэлд орсон, зээлийн эргэн төлөлт нь олон сарын зөрчилтэй зээлдэгчийн төсөл хэвийн явагдах үндэслэлтэй гэж үзвэл төсөл хэрэгжүүлж буй бизнесийг үнэлэх, нэгтгэх, нийлүүлэх, зарах боломжийг олгох; Хувийн хөрөнгө оруулалтын сангуудтай санхүүжилт олгох, зээлийг худалдаж авах, зарах чиглэлээр хамтран ажиллах” ... шүүхийн бус журмаар зээлийг төлүүлэх,
4. “Төсөл хэвийн явагдах үндэслэлтэй гэж үзвэл төсөл хэрэгжүүлж буй бизнесийг үнэлэх, нэгтгэх, нийлүүлэх, зарах боломжийг олгох”... шүүхийн бус журмаар зээлийг төлүүлэх ажиллагаа явуулж байна.

УИХ-ын 2023 оны хянан шалгах түр хорооноос өгсөн зөвлөмжийн 60 хувь нь биелээгүй байна

2.8 Монгол Улсын Их Хурлын 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор байгуулагдсан “Хянан шалгах Түр хороо”-ны тус банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, зээл олголт, эргэн төлөлтийн явц, байдалд үнэлэлт, дүгнэлт гаргасан тайлан УИХ-ын цахим хуудсанд 2023 оны 04 сарын 21-нд байршсанаар олон нийтэд нээлттэй болж, уг тайлангаар 3 саналд үндэслэсэн дараах 4 хэсэгт 11 зөвлөмжийг өгсөн байна. Үүнд:

1. Банкны үйл ажиллагааны чиглэлийг олон улсын сайн туршлагад нийцүүлэх, Компанийн засаглалын зохистой зарчмыг хэрэгжүүлэх, төрийн томилгоог халах, Банкны хяналт шалгалтын тогтолцоог олон улсын банк, санхүүгийн тогтолцоо, стандарт, дүрэм журамтай нийцүүлэх, хууль тогтоомж, журам зааварт өөрчлөлт оруулах тухай 4,
2. Санхүүгийн өнөөгийн нөхцөл байдалд үнэлэлт хийх, активын чанарын үнэлгээг гаргах, эх үүсвэрийн эргэн төлөлт, балансын бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөөг боловсруулах, Зах зээлийн эрсдэлийн хэм хэмжээг тогтоож, актив, пассивын хугацааны болон хүүгийн шинжилгээг нарийвчлан хийх, бизнес загварын хувьд дахин өөрчлөн байгуулалт хийх, шаардлагатай бол үйл ажиллагааг төрөлжүүлэх чиглэлээр 2,
3. Банкны засаглалын бодлого, Эрсдэлийн бодлогыг боловсруулан баталж, хэрэгжүүлэх болон дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх, Банкны үйл ажиллагаатай холбоотой аливаа асуудлыг мэргэжлийн түвшинд сонирхлын зөрчилгүй, хараат бус байдлаар шийдвэрлэх чадвартай ТУЗ-ийн гишүүдийг томилох; ТУЗ-ийн гишүүдтэй гэрээ байгуулах, Гүйцэтгэх удирдлагын багийг багаар нь сонгон шалгаруулж, гэрээ хийн үнэлэлт дүгнэлт хийн ажилладаг байх тухай 3,
4. Олон улсын жишгээр хөгжлийн банкны 72 хувь нь Төв банкны, 28 хувь нь Засгийн газрын хяналтад байгааг харгалзан үр ашигтай, зохистой хяналтын тогтолцоог бий болгох, Банкны хяналт шалгалтын тогтолцоог олон улсын банк, санхүүгийн стандартад нийцүүлж, энэ хүрээнд холбогдох эрх зүйн орчин, дүрэм журмуудыг тогтоох тухай 2 зөвлөмжийг тус тус өгсөн байна.

2.9 Тус банкнаас Улсын Их Хурлын 2022 оны 14 дүгээр тогтоолоор байгуулагдсан “Хянан шалгах Түр хороо”-ноос өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар авч үзэхэд 10 зөвлөмж хэрэгжиж буй, 1 зөвлөмж хэрэгжээгүй, биелэлт 40 хувьтай боловч төлөвлөгөөний хэрэгжиж дуусах хугацаа, хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлт тодорхойгүй байна. Тухайлбал:

- Тус банкны гүйцэтгэх удирдлагаас банкны алдаа сургамж, цаашид авах шаардлагатай арга хэмжээний талаар МУХБ-ны хууль, эрх зүйн орчин, сайжруулалт, Банкны засаглал, удирдлага, Санхүүжилтийн үйл ажиллагаа, Зохицуулалт, хяналтын тогтолцоо ба эрсдэлийн удирдлага,

Банкны хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, Бусад орны хөгжлийн банкууд гэсэн 6 бүлэг асуудал болгон Хувьцаа эзэмшигчдэд 2023.04.06-нд 2/410 тоотгоор хүргүүлсэн.

- Азийн хөгжлийн банкнаас Худалдааны санхүүжилт, Компанийн засаглал, Төслийн санхүүжилт, СТОУС-9 нэвтрүүлэх чиглэлээр техникийн туслалцаа авах санал хүргүүлсэн⁷ бөгөөд Азийн Хөгжлийн Банкнаас техникийн туслалцааг 2024 онд эхлүүлэхээр төлөвлөж /Азийн хөгжлийн банкны техник туслалцааны хүрээнд бодлогын чанартай томоохон санал, зөвлөмжүүд гарснаар Банкны бизнес загвар тодорхой болж, холбогдох дүрэм журмуудад өөрчлөлт хийх/ байна.
- МУХБ болон “Обзервстар” ХХК-ийн хооронд байгуулсан “Авлигын эсрэг менежментийн тогтолцооны олон улсын стандарт ISO37001-ийг нэвтрүүлэх гэрээг 2023 оны 10 сарын 25-нд байгуулсан байна,
- МУХБ болон “Инфосек Интелиженс” ХХК-ийн хооронд Монгол Улсын хөгжлийн банканд нэгдсэн менежментийн тогтолцоо ISO27001-ийг нэвтрүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулан “Зөвлөх үйлчилгээ үзүүлэх” гэрээг 2023 оны 10 сарын 05-нд байгуулсан байна,
- Сангийн сайдын 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 121 тоот тушаалаар байгуулагдсан “Ажлын хэсэг” тус банкны ТУЗ-ийн ердийн гишүүний сонгон шалгаруулалтыг зохион байгуулж⁸, ТУЗ-ын гишүүдийг санал хураалтаар сонгон шалгаруулж томилсон байна.

2.10 УИХ-ын 2016 оны 12 сарын 28-ны өдрийн 81 дүгээр тогтоолоор Засгийн газар, Монгол Улсын Хөгжлийн банк хооронд улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй үүссэн өр, авлагын тооцоог 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон харилцан суутгах замаар эцэслэн шийдвэрлэх чиглэлийг гаргасан байна.

2.11 УИХ-ын 81 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх үед Монгол Улсын Хөгжлийн банкны зохистой харьцааны холбогдох шалгуур үзүүлэлтийг сайжруулах төслөөр “Сайншанд аж үйлдвэрийн цогцолбор” ТӨХХК-ийн МУХБ дахь 3600000577USD дансанд 550.4 мянган ам.доллар (1,881,817,600.00 төгрөг), 3600000578MNT дахь дансанд 77,1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан бөгөөд Засгийн газрын 2018 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн 9 дүгээр тогтоолоор Сайншанд аж үйлдвэрийн цогцолборыг татан буулгах шийдвэр гарснаар дээрх дансны үлдэгдлийг эргэлтэд оруулах, үр нөлөө гаргах боломжгүй болжээ. Иймд аудитаар нийт 1.88 тэрбум төгрөгийг төсөвт төвлөрүүлэх хугацаатай албан шаардлагыг хүргүүлж байна.

ҮАГ-аас 2021-2022 оны өгсөн зөвлөмжийн 17 хувь, албан шаардлагын 62.5 хувь нь биелээгүй байна

2.12 МУХБ-аас ҮАГ-аас хийсэн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлага, төлбөрийн актын биелэлтийг ҮАГ-т 2023 оны 5 сарын 03-ны өдрийн 3/511 дугаартай албан бичгээр хэрэгжилтийг тайлагнасан байна. Үүнд:

- Нийт 7 зөвлөмж өгснөөс 5 зөвлөмж хэрэгжиж, 2 зөвлөмж хэрэгжих шатанд, 15 албан шаардлага өгснөөс 5 хэрэгжсэн, 5 хэрэгжих шатанд, 1 хэрэгжилт хангалтагүй, 4 хэрэгжээгүй, 90.5 сая төгрөгийн төлбөрийн акт барагдсан.

2.13 Харин Засгийн газрын 2022 оны 220 дугаар тогтоолоор зээлийн өр төлбөрийн барагдуулах шийдвэр гаргасан ч ҮАГ-аас өгсөн албан шаардлагын хэрэгжилтээс тодорхой үр дүн гараагүй байна. Тухайлбал:

- “Ди Би Эм Ассет менежмент ҮЦК” ХХК болон “Дархан арьс ширний цогцолбор” ХХК хооронд байгуулсан гэрээний дагуу нийт 6,488.4 сая төгрөгийн зээлийн төлбөр төлөгдөөгүй, зээлдэгчээр зээлийн гэрээний үүргийг биелүүлж ажиллаагүй гэх албан шаардлагын дагуу ХХААХҮЯ-ны харьяа ДАШЦББ төрийн өмчит ХХК-д шилжүүлэн өгөх замаар өр төлбөрийг барагдуулах хэлэлцээрийг “Дархан арьс ширний цогцолбор” ХХК болон ХХААХҮЯ-тай хийсэн ч тодорхой үр дүнд хүрээгүй, Банкнаас Авлигатай тэмцэх газарт хандаж хохирогч, иргэний нэхэмжлэгчээр тогтоолгох хүсэлт гаргасан;

⁷ хүсэлтийг 2022 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 2/1447 тоотгоор хүргүүлсэн, АХБ-аас 2023 оны 7 дугаар сарын 7-ны өдөр Ажлын даалгаврын төслийг ирүүлсэн

⁸ Төрийн захиргааны албан хаагчийн нэрийг ирүүлэх тухай 2023 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 12/3126 тоот албан бичгийг ЗГХЭГ, ЭЗХЯ, ХДХЯ, Монголбанк, СЗХ, ТӨБЗГ-т 2023 оны 05 дугаар сарын 10-ны өдөр хүргүүлсэн. Мөн ТУЗ-ийн гишүүнийг нээлттэй сонгон шалгаруулах зарыг 2023.05.04-2023.05.19-ний өдрийг дуустал Сангийн яам болон МУХБ-ны цахим хуудас, түүнчлэн өдөр тутмын хэвлэл мэдээллийн хэрэгсэлд байршуулсан

- Хөгжлийн банк нь бие даан шийдвэрлэх эсвэл төрийн бусад байгууллагуудын адил тогтоол шийдвэр журмын хэрэгжилтийг дагаж мөрддөг байх эсэхийг нэг талд нь гаргаж шийдвэрлэх зайлшгүй шаардлагатай байна гэсэн албан шаардлага биелэгдээгүй, ТХТХ-ийн хүрээнд ТӨБЗГ-аас ирсэн албан бичиг, Засгийн газрын шийдвэрийн хүрээнд хөрөнгийг шилжүүлсэн байна;
- “Барилгын хийц үйлдвэрлэх хөдөлгөөнт цогцолбор” зээлийг Засгийн газрын 2016 оны 60 дугаар тогтоолоор Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэлд “Барилгын хийц үйлдвэрлэх хөдөлгөөнт цогцолбор”-ын тоног төхөөрөмжийг худалдан авахад зориулж ТОСК ТӨҮГ-аар дамжуулан 2016 онд 7,055.255 ам.долларын зээлийг олгосон. Засгийн газрын 2017 оны 48 дугаар тогтоолоор уг тоног төхөөрөмжийг худалдан авахад зориулж олгосон нийт 25,649.9 сая төгрөгийг, үүнээс зээл, зээлийн хүү нийт 10.4 сая ам.доллар, 153.1 сая төгрөгийг улсын төсөвт тусгах, Батлан хамгаалах яамны балансад шилжүүлэхээр заасан боловч уг тогтоолыг хэрэгжүүлээгүй байна.
- 2017 онд тус банкнаас⁹ “Эгийн голын усан цахилгаан станц” ТӨХК-д 10.6 сая ам.долларын зээлийг хэсэгчлэн олгосон ба зээлийн хугацаа 2021 онд дуусгавар болж зээл, зээлийн хүү, торгуулийн төлбөр нийт 15.0 сая ам.долларын 43,038.3 сая төгрөгийн зээлийн эргэн төлөлт хийгдээгүй байна.
- Засгийн газрын 2013 оны 80 тогтоолыг үндэслэн¹⁰ “Тавантолгойн цахилгаан станц” төслийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангахад тус банкаас эхний ээлжид 1.9 сая ам.долларын зээл олгож, Засгийн газрын 2014 оны 261 дүгээр тогтоолын¹¹ дагуу дахин нийт 15.9 сая долларын зээл олгосон байна. Зээлийн хугацаа 2022 оны 6 сард дууссан ч гэрээнд заасан хугацаанд зээлийн төлөлт хийгдээгүй байна.
- Засгийн газрын 2020 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн 155 дугаар тогтоолоор “Ди Би Эм Ассет менежмент ҮЦК” ХХК болон “Ди Би Эм лизинг” ХХК-ийг татан буулгаж, 2021 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн 252 дугаар тогтоолоор 2 охин компанийг татан буулгах ажиллагааг зогсоож, үйл ажиллагааг сэргээхийг Монгол Улсын Хөгжлийн банканд даалгаж, Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2021 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 08 дугаар шийдвэрээр дүрмийг дахин баталж, компанийн үйл ажиллагаа сэргээсэн байна.

2.14 ҮАГ-аас 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд 5 зөвлөмж, 1 албан шаардлагыг тус банканд өгч 2023 оны 9 дүгээр сарын 4-ний өдрийн 5/920 тоот албан бичгээр албан шаардлагын хэрэгжилтийг ҮАГ болон Сангийн яаманд хүргүүлж тайлагнасан байна.

Монголбанкны зөвлөмжийн 38.5 хувь нь хэрэгжээгүй байна

2.15 Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 12 дугаар сарын А/336 дугаар тушаалаар МУХБ-д хийсэн хяналт шалгалтын дүнг баталж, 13 зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг ТУЗ, гүйцэтгэх захирал нарт үүрэг болгож, 8 зөвлөмж хэрэгжиж, 5 зөвлөмж хэрэгжих шатандаа байна. Тухайлбал:

Хэрэгжих шатанд байгаа зөвлөмж:

- Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт заасан Хөгжлийн банкнаас санхүүжүүлэх төсөл хөтөлбөрт тавигдах шаардлагыг хангасан эсэхийг үнэлэх, дүгнэлт өгөх тодорхой шалгуур, аргачлал, зааврыг шинэчилж, мөрдөх зөвлөмжийн хүрээнд “Санхүүжилтийн бодлого”-ын төслийг боловсруулж гүйцэтгэх удирдлагад танилцуулж баталгаажуулан ТУЗ-д хүргүүлсэн. Учир нь энэхүү баримт бичиг нь МУХБ-ны тухай хуулийн дагуу ТУЗ-ийн шийдвэрлэх, батлах хүрээний асуудал бөгөөд ТУЗ нь уг бодлогын төслийг МУХБ-ны хуулийн шинэчлэлтэй уялдуулан сайжруулах чиглэл өгсөн тул хүлээгдэж байна.
- Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэгт заасан шаардлага хангасан төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэхдээ гадаад, дотоодын банк, санхүүгийн байгууллага, хөрөнгө оруулагчидтай хамтран санхүүжүүлэх заалтыг хангасан эсэхийг үнэлэх, дүгнэлт өгөх тодорхой шалгуур, аргачлал, зааврыг шинэчилж, мөрдөх зөвлөмжийн хүрээнд МУХБ-ны “Зээлийн бодлого” болон “Төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх шийдвэр гаргах журам”-уудын шинэчилсэн найруулгын төсөлд Хөгжлийн банкнаас санхүүжүүлэх төсөл хөтөлбөрт тавигдах шаардлагыг нэмэгдүүлж, түүнд үнэлэлт дүгнэлт өгөх шалгуур, аргачлал, зааврыг нарийвчлан тусгасан байна.

⁹ “Монгол Улсын Хөгжлийн банк”, ЭХЯ, ТӨБЗГ, “Эгийн голын усан цахилгаан станц” ТӨХК-тай ТС-ЭГ-ЗҮ 2017/131 дугаартай “Төсөл санхүүжүүлэх, эргэн төлөлтийг зохицуулах тухай гэрээ”-г байгуулсан

¹⁰ “Эрчим хүчний яам”, “Эдийн засгийн Хөгжлийн яам” болон “Монгол Улсын Хөгжлийн банк” хооронд “Төсөл санхүүжүүлэх, эргэн төлөлтийг зохицуулах тухай” гэрээг 2013 онд байгуулж,

¹¹ төслийн бэлтгэл ажилд шаардлагатай санхүүжилт болон “Төсөл санхүүжүүлэх, эргэн төлөлтийг зохицуулах тухай” 3-ДЦ-Б 2014-09 дугаартай гэрээг дахин шинэчилсэн

- Чанаргүй активыг төлүүлэх талаар шүүх, хууль, хяналтын байгууллагад тухай бүр хандаж ажиллах, банкнаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээг эрчимжүүлэх, барьцаа хөрөнгөөгүй зээлүүдийг барьцаажуулах, барьцаа хөрөнгө хангалтгүй зээлүүдэд нэмж хөрөнгө барьцаалах зөвлөмжийн хүрээнд чанаргүй зээлийн эргэн төлөлт эрчимжиж, барьцаа хөрөнгө хангалтгүй зарим зээлүүдэд нэмж хөрөнгө барьцаалсан байна.
- Гадаад валютын эх үүсвэрээр гадаад валютаар орлого олдог зээлдэгчийн хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийг санхүүжүүлдэг байх талаар зээлийн бодлого, журамд тусган, мөрдөж ажиллах талаар өгсөн зөвлөмжийн хүрээнд валютын орлогогүй зээлдэгчид валютын зээл олгохгүй байхаар холбогдох журамд өөрчлөлтийг тусгасан.
- Арилжааны банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний холбогдох болон харилцан хамаарал бүхий этгээдэд олгох зээлийг хязгаарлах, банкны хөрөнгө, орлогыг барьцаанд барьцаалахгүй байх, банкны хувьцаа эзэмшигчээр гаргуулах баталгаа, батлан даалтыг хязгаарлах талаар дотоод журам зааварт тусган, хэрэгжүүлэх зөвлөмжийн хүрээнд гуравдагч мэдээллийн сан бүхий “Sanctions Compliance” программыг улс төрд нөлөө бүхий этгээд эсэх, холбогдох хамаарлыг шалган ажиллаж байна.

Олон улсын аудитын компаниас өгсөн зөвлөмжийн 47 хувь нь хэрэгжээгүй байна

2.16 Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-г¹² заасны дагуу тус банкны 2020-2022 оны санхүүгийн тайланг олон улсын хөндлөнгийн “Кэй Пи Эм Жи Аудит” ХХК (KPMG) баталгаажуулж, 2020 онд 30, 2021 онд 25, 2022 онд 21 нийт 76 зөвлөмжийг өгсөн байна.

2.17 Олон улсын хөндлөнгийн “Кэй Пи Эм Жи Аудит” ХХК аудитаас өгсөн нийт 76 зөвлөмжийн 40 буюу 53 хувь нь хэрэгжсэн, 36 буюу 47 хувь нь хэрэгжих шатандаа явж байна. Санхүүгийн аудитаас өгсөн зөвлөмжүүд сүүлийн 3 жилд буурч байгаа ба агуулгын хувьд 2-3 давтагдсан 21 зөвлөмж байна. Эдгээр нь СТОУС-ийн байнгын шинэчлэлт, зээлийн ирээдүйн мөнгөн урсгал, тухайлсан зээлийн төсөөлөл, санхүүгийн хэрэгслийн бодит үнэ цэний үнэлгээ зэрэг тооцооллыг хийх, хянах ажиллагааг сайжруулах, боловсон хүчнийг байнгын мэргэшүүлэх сургалтад хамруулах ажлуудад чиглэгдсэн байна.

- Санхүүгийн хөндлөнгийн аудитын зөвлөмжийг хэрэгжүүлснээр банкны үйл ажиллагаанд олон улсын шинэчлэгдсэн стандартыг санхүүгийн үйл ажиллагаанд байнга нэвтэрч, үндсэн бүртгэлийн систем болон банканд ашиглагдаж байгаа бүх серверүүдийг өндөр хамгаалалттай байлгаж, мэдээллийн аюулгүй байдал хангагдсан, эрсдэлийн газрын үйл ажиллагааг хараат бус, бодитоор хянах боломж бүрдэж, тайлан мэдээний автоматжуулалт, хөгжүүлэлтийг тогтмол хийснээр санхүүгийн тайлан, тодруулгууд боловсруулахад гарах алдааг бууруулсан зэрэг үр дүн гарч эхэлж байна.

2.18 Хөгжлийн банкны ТУЗ-ийн 2021 оны 03 дугаар, 2023 он 05, 18 дугаар тогтоолоор жилийн эцсийн санхүүгийн тайланд хийгдсэн аудитаар өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулж, шаардлагатай арга хэмжээг авч, үр дүнг эргэн танилцуулахыг гүйцэтгэх захиралд үүрэг болгосон ч гүйцэтгэх удирдлагаас 2021-2023 онд “Кэй Пи Эм Жи Аудит” ХХК-с өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулж батлуулах, шаардлагатай арга хэмжээг авч үр дүнг ТУЗ-д танилцуулах хугацаатай үүргийг биелүүлээгүй байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг тус банкны охин компани хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангаа хуульд заасны дагуу Төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй байна.

2.19 Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21¹ дүгээр зүйлийн 21¹.9-д “Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийлгэнэ” -гэж заасныг тус банкны 2 охин компани хэрэгжүүлж ажиллаагүй, Төрийн аудитын байгууллагад санхүүгийн тайлангаа хүргүүлээгүй байна. Үүнд:

¹² Хөгжлийн банкны санхүүгийн тайланд төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр сонгосон олон улсын нэр хүнд бүхий аудитын байгууллагаар жил бүр аудит хийлгэж, дүгнэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн хамт төлөөлөн удирдах зөвлөлөөс Монголбанк, Засгийн газарт хүргүүлнэ

- Тус банкны охин компани болох “Ди Би Эм ассет менежмент ХХК” -ийн 2020, 2022 оны санхүүгийн тайлангаа Төрийн аудитын байгууллагад хүргүүлээгүй.
- “Ди Би Эм лизинг ХХК”-ийн 2020, 2021, 2022 оны санхүүгийн тайлангаа Төрийн аудитын байгууллагад тус тус ирүүлээгүй.

2.20 МУХБ-ны тухай хуулийн 29.1-д “Хөгжлийн банкны санхүүгийн тайланд төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр сонгосон олон улсын нэр хүнд бүхий аудитын байгууллагаар жил бүр аудит хийлгэж, дүгнэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн хамт төлөөлөн удирдах зөвлөлөөс Монголбанк, Засгийн газарт хүргүүлнэ.”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21¹ дүгээр зүйлийн 21¹.9-д “Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийлгэнэ” гэсэн хуулийн заалтууд хоорондоо уялдаагүй байна.

2.21 Хөгжлийн банк 2020-2022 онд санхүүгийн тайланд аудит хийлгэх гэрээ байгуулан доорх байдлаар зардлыг гаргасан байна. Тухайлбал:

- УАГ-ын гэрээт хараат бус аудитын хуулийн этгээд “Грант торнтон” ХХК-иар 2021 оны санхүүгийн тайланг баталгаажуулахад 80.0 сая төгрөг
- Олон улсад зөвшөөрөгдсөн “Кэй Пи Эм Жи Аудит” ХХК-р 2020-2022 оны санхүүгийн тайланг баталгаажуулахад 2020 онд 330.0 сая, 2021 онд 350.0 сая, 2022 онд 350.0 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

ДҮГНЭЛТ:

1. ТУЗ-өөс 2020-2023 оны хооронд 5 удаа орон тооны дээд хязгаарыг баталж, 3 удаагийн бүтэц, зохион байгуулалтыг хийснээр 2022-2023 оны хооронд 129 орон тооноос 89 орон тоо буюу 68.9 хувь нь ажлаас чөлөөлөгдөж, үүнээс мэргэжилтэн 91, хэлтсийн болон газрын захирал 31 байгаа нь хүний нөөцийн хөдөлгөөн ихтэй, банкны үйл ажиллагааг хэвийн, тогтвортой явуулахад хүндрэл учрахаар байна.
2. Зээлийн үлдэгдэл 2023 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн байдлаар 40 зээлдэгчийн 2,254.6 тэрбум төгрөг болж, үүнээс чанаргүй зээл 1,270.1 тэрбум буюу 56.3 хувьд хүрч өссөн, Төрийн өмчит ТОСК-ийн “Хөдөлгөөнт цогцолбор”, Эрчим хүчний яамны Таван толгой дулааны цахилгаан станц, “Эгийн голын УЦС” ХХК-ийн зээлийн эргэн төлөлт хийгдээгүй байна.
3. УИХ, УАГ, Монгол банк, Сангийн яам зэрэг төрийн байгууллага, олон улсын хөндлөнгийн аудит “Кэй Пи Эм Жи Аудит” ХХК эрх бүхий байгууллагаас тус банкны үйл ажиллагаанд 2020-2022 онд хийсэн хяналт шалгалт, аудитаар нийт 154 зөвлөмжийг өгснөөс 64 буюу 41.6 хувь нь биелж, 90 буюу 58.4 хувь биелээгүй нь ТУЗ болон дотоод аудитын хорооноос зөвлөмж хэрэгжүүлэх, шийдэл төлөвлөгөөг тухай бүр оновчтой гаргаагүйтэй холбоотой байна.
4. УИХ-ын 81 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх үед Монгол Улсын Хөгжлийн банкны зохистой харьцааны холбогдох шалгуур үзүүлэлтийг сайжруулах төслөөр “Сайншанд аж үйлдвэрийн цогцолбор” ТӨХХК-ийн МУХБ дахь 3600000577USD дансанд 550.4 мянган ам.доллар (1,881,817,600.00 төгрөг), 3600000578MNT дахь дансанд 77,1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан бөгөөд Засгийн газрын 2018 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн 9 дугаар тогтоолоор Сайншанд аж үйлдвэрийн цогцолборыг татан буулгах шийдвэр гарснаар дээрх дансны үлдэгдлийг эргэлтэд оруулах, үр нөлөө гаргах боломжгүй болжээ.

ЗӨВЛӨМЖ:

Гүйцэтгэх удирдлагад:

1. Банкны хүний нөөцийг тогтвортой ажиллахад анхаарч, төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, банкны үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэх
2. Засгийн газрын 2022 оны 220 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулж, Төрийн өмчит ТОСК-ийн “Хөдөлгөөнт цогцолбор”, Эрчим хүчний яамны Таван толгой дулааны цахилгаан станц, “Эгийн голын УЦС” ХХК-ийн зээлийн эргэн төлөлтөд анхаарч ажиллах
3. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21¹ дүгээр зүйлийн 21^{1.9} дэх заалтыг хэрэгжүүлж, охин компанийн санхүүгийн тайланг Төрийн аудитын байгууллагад хүргүүлж байх
4. Зээлийн төлөлтийг эрчимжүүлж, чанаргүй зээлийн ангиллыг бууруулах үе шаттай арга хэмжээ авч хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган ТУЗ-д танилцуулж шийдвэрлүүлэх
5. Эрх бүхий байгууллагаас өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэх, хэрэгжээгүй зөвлөмжийг хяналтдаа авч цаашид эрчимжүүлэх арга хэмжээ авах

Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал:



МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНК

Энхтайваны өргөн чөлөө 19, 1 дүгээр хороо,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14210
Утас: (+976) 7013 0513, Факс: (+976) 7013 0602
Цахим хуудас: www.dbm.mn

2023. 12. 27 № 2/1489
танай _____-ны № _____-т

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
ГҮЙЦЭТГЭЛ-НИЙЦЛИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Д.ЭНХБОЛД ТАНАА

Тайлангийн төсөлд санал
хүргүүлэх тухай

Танайхаас ирүүлсэн “Хөгжлийн банкны үйл ажиллагааны үр нөлөө, үр ашиг”-ийн тайлангийн төсөлтэй танилцан дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

- 2020-2021 онуудад Хөгжлийн банк алдагдалтай ажилласан, мөн чанаргүй зээлийн хэмжээ 1.8 их наяд төгрөгт хүрсэн тул 2022 оны 1 дүгээр сараас банкны зээлийн багцын мэдээллийг олон нийтэд нээлттэй зарлаж хугацааны зөрчилтэй болон чанаргүй зээлүүдийг барагдуулах арга хэмжээг эрчимжүүлсэн билээ. Тайлангийн нүүр хэсэгт “чанаргүй зээлийн хэмжээ 1,270.1 тэрбум төгрөгт буюу 56.3 хувьд хүртэл өсөж” гэсэн агуулгатай байгаа 2022-2023 онуудад банкнаас чанаргүй зээлийг бууруулахтай холбоотой авч хэрэгжүүлсэн арга хэмжээг үгүйсгэсэн агуулгатай байна. Түүнчлэн 2022-2023 онуудад зээлийн эргэн төлөлтөөс нийт 1.6 их наяд төгрөгийн зээлийг төлүүлсэн бөгөөд үүний 88.4 хувийг хугацааны зөрчилтэй, чанаргүй ангилалтай байсан зээлдэгчдээс төлүүлсэн байна. Иймд агуулгыг 2020-2023 онуудыг хамааруулахаар дараах байдлаар найруулж, өөрчлөх саналтай байна.

Монгол Улсын Хөгжлийн банк 2020-2021 онуудад 81.6-306.7 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллаж, чанаргүй зээлийн хэмжээ 1.8 их наяд төгрөгт хүрсэн ч, Банкнаас 2022-2023 онуудад чанаргүй зээлийг барагдуулах, гадаад өр төлбөрүүдийг амжилттай төлөх арга хэмжээ авч ажилласан байна. (хуудас-1)

- Тайлангийн төслийн агуулгад “Хөндлөнгийн хяналтын байгууллагын зөвлөмжийн 58.4 хувь хэрэгжээгүй” гэсэн ба Хөгжлийн банкны өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдлөг болгон ажиллаж буй зөвлөмжүүдийг тайланд хэрэгжиж буй гэсэн ангилалтай байгаа боловч тайлангийн нүүр болон дэд гарчигт хэрэгжээгүй гэх агуулгатай оруулсан байна. Ийнхүү хэрэгжиж буй 72 зөвлөмж, хэрэгжээгүй 6 зөвлөмжийг нийлүүлж хэрэгжээгүй ангилалд оруулж тайлагнаж байгаа нь бодит байдалтай нийцэхгүй байна. Тайланд хэрэгжүүлээгүй 6 зөвлөмж байгаа бөгөөд эдгээр зөвлөмж нь Хөгжлийн банкнаас дангаар шийдвэрлэх боломжгүй, холбогдох арга хэмжээг авсан ч шийдвэрлэх шатанд дэмжигдээгүй асуудлууд байна. Иймд агуулгыг доорх байдлаар өөрчлөх саналтай байна.

- Хөндлөнгийн хяналтын байгууллагын зөвлөмжийн 41.6 хувь нь хэрэгжсэн, 55.2 хувь нь хэрэгжиж буй, 3.2 хувь нь хэрэгжээгүй байна. (хуудас-1,12)

- Монгол Улсын Их Хурлын 2022 оны хяналт, шалгалтын зөвлөмжийн 27.3 хувь нь хэрэгжсэн, 43.8 хувь нь хэрэгжиж буй, 15.6 хувь нь хэрэгжээгүй байна. (хуудас-12,13)
- УИХ-ын 2023 оны Хянан шалгах түр хорооноос өгсөн зөвлөмжийн 90.9 хувь хэрэгжиж буй, 9.1 хувь нь хэрэгжээгүй байна. (хуудас-14)
- ҮАГ-аас 2021-2022 онуудад хийсэн аудитын зөвлөмжийн 77.8 хувь нь хэрэгжсэн, 22.2 хувь нь хэрэгжиж буй байдалтай байна. (хуудас- 12,15,16)
- Хөндлөнгийн аудит болох КРМГ-аас 2020-2022 онуудад өгсөн аудитын зөвлөмжийн 52.6 хувь нь хэрэгжсэн, 47.4 хувь нь хэрэгжиж буй байдалтай байна. (хуудас- 12,17,18)

- Төрийн эрх бүхий байгууллагаас хийсэн хяналт шалгалт, аудитын зөвлөмжийн хэрэгжилт, биелэлтийг холбогдох байгууллагуудад хүргүүлж байсан тухай дурдсан бөгөөд Монголбанкны 2021 оны хяналт, шалгалтын тайланг улирал бүр хүргүүлдэг тул холбогдох өөрчлөлтийг хийж тусгах саналтай байна. Мөн холбогдох баримтыг хавсаргав.

Монголбанкны 2021 оны хяналт, шалгалтын 2023 оны 3 дугаар улирлын тайланг 2023 оны 10 дугаар сарын 17-ны 2/1130 дугаар албан бичгээр хүргүүлсэн байна. (хуудас- 12)

Банкны охин компаниуд болох “Ди Би Эм Ассет Менежмент ҮЦК” ХХК, “Ди Би Эм Лизинг” ХХК нарт цаашид аудитлагдсан санхүүгийн тайлангаа Үндэсний аудитын газарт холбогдох хуулийн хугацаанд хүргүүлж байх талаар мэдэгдсэн бөгөөд Банкны зүгээс хяналт тавин ажиллах болно. Мөн охин компаниудын гүйцэтгэх захирал нарт “Хөдөлмөрийн тухай хууль”-д заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулсан болно. Холбогдох баримтыг хавсаргав.

Хүндэтгэсэн,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Ж.БАТАА

Үндэсний аудитын газрын тайлбар

Монгол Улсын Хөгжлийн банкнаас ирүүлсэн 3 санал мэдээллийн шинж чанартай тул тайланд өөрчлөлт оруулаагүй болно.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН СЭДЭВ: “ХӨГЖЛИЙН БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР НӨЛӨӨ, ҮР АШИГ”

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНК 2020-2021 ОНЫ ХООРОНД 81.6-306.7 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН АЛДАГДАЛТАЙ АЖИЛЛАЖ, 2023 ОНЫ 12 САРЫН 14-НИЙ БАЙДЛААР ЧАНАРГҮЙ ЗЭЭЛ 1,270.1 ТЭРБУМ ТӨГРӨГ БУЮУ 56.3 ХУВЬД ХҮРТЭЛ ӨСӨЖ, ХӨНДЛӨНГИЙН ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ЗӨВЛӨМЖИЙН 58.4 ХУВЬ НЬ ХЭРЭГЖЭЭГҮЙ БАЙНА.

Улаанбаатар хот, 2023 он